ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ХЭА-2022/08/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.audit.mn

Чингис хот

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Б.Ариунаа
Утас: 93032714

Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....................4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....................4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....................5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ....................6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....................7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....................8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ....................9
3. Аудитын тайлан ....................10
3.1 Ерөнхий зүйл ....................10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....................10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....................10
3.4 Материаллаг байдал ....................11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....................11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....................12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....................13
3.8 Аудитын гол асуудал ....................13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....................13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ....................13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....................13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....................13
4. Аудитын илрүүлэлт ....................14
4.1 Залруулсан алдаа ....................14
4.2 Төлбөрийн акт ....................14
Ээлжийн амралтын хоногийн тооцоог хийгээгүй 0.5 сая төгрөгийн цалин давхардуулан олгосон байна. ....................14
4.3 Албан шаардлага ....................14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....................15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.02.25 № 33

танай ____________ -ны № ______________ -т

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР - 419 ДҮГЭЭР ХОРИХ АНГИЙН ДАРГА,ХУРАНДАА Д.ХАТАНБААТАР ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар - 419 дүгээр нээлттэй хорих ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭРДЭНЭБААТАР

0230300

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 410,882,148.31 | 404,422,742.46 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 10,063,901.86 | 10,341,643.66 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 10,063,901.86 | 10,341,643.66 |
| 3121 | Төгрөг | 10,063,901.86 | 10,341,643.66 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 10,063,901.86 | 10,341,643.66 |
| 33 | АВЛАГА | 3,397,758.00 | 1,465,758.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 32,000.00 | - |
| 335 | Бусад авлага | 3,365,758.00 | 1,465,758.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 3,365,758.00 | 1,465,758.00 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 1,870,000.15 | 1,870,000.15 |
| 3471 | Урьдчилгаа тооцоо | 1,870,000.15 | 1,870,000.15 |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 1,870,000.15 | 1,870,000.15 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 395,550,488.30 | 390,745,340.65 |
| 351 | Түүхий эд материал | 50,649,095.00 | 68,572,910.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 47,318,055.00 | 64,608,710.00 |
| 35130 | Эм боох материал | 3,331,040.00 | 3,964,200.00 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | 10,340,000.00 | - |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 1,177,851.50 | 28,750.00 |
| 354 | Хангамжийн материал | 152,103,541.80 | 168,853,680.65 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 557,300.00 | 560,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 71,268,134.55 | 93,294,982.65 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | 516,710.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 27,066,210.00 | 8,371,330.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,079,000.00 | 1,045,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 47,176,344.00 | 59,979,658.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 4,956,553.25 | 5,086,000.00 |
| 35600 | Мал амьтад | 181,280,000.00 | 153,290,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 3,720,958,909.58 | 3,691,638,621.97 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,720,958,909.58 | 3,691,638,621.97 |
| 392 | Биет хөрөнгө | 1,503,238,865.90 | 1,470,658,321.97 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,270,520,553.01 | 1,297,990,453.89 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (106,064,260.80) | (155,838,168.12) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 397,202,264.00 | 249,465,922.80 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (264,846,532.43) | (122,571,196.75) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 276,877,790.81 | 311,658,631.81 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (139,090,319.11) | (178,147,601.39) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 36,131,599.20 | 36,131,599.20 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (23,512,164.62) | (28,354,065.94) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 10,605,142.00 | 10,605,142.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (4,394,778.38) | (4,783,410.14) |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 25,409,344.00 | 25,409,344.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 55,010,332.00 | 63,608,665.12 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (30,610,103.78) | (34,516,994.51) |
| 393 | Биет бус хөрөнгө | 2,217,720,043.68 | 2,220,980,300.00 |
| 39301 | Програм хангамж | 6,417,692.31 | 6,417,692.31 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (6,177,948.63) | (6,417,692.31) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2,217,480,300.00 | 2,220,980,300.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 4,131,841,057.89 | 4,096,061,364.43 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 34,126,550.63 | 34,340,292.37 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 34,126,550.63 | 34,340,292.37 |
| 413 | Өглөг | 34,126,550.63 | 34,340,292.37 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 32,000.06 | 150,211.75 |
| 4136 | Бусад өглөг | 34,094,550.57 | 34,190,080.62 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 34,094,550.57 | 34,190,080.62 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 4,097,714,507.26 | 4,061,721,072.06 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 4,097,714,507.26 | 4,061,721,072.06 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,688,790,820.02 | 2,688,790,820.02 |
| 51101 | Өмч: - төрийн | 2,688,790,820.02 | 2,688,790,820.02 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 744,296,466.98 | 708,479,831.78 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 744,296,466.98 | 744,473,266.98 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (35,993,435.20) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 664,627,220.26 | 664,450,420.26 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 4,131,841,057.89 | 4,096,061,364.43 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,061,751,777.01** | **1,825,413,471.80** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **309,281,577.01** | **249,698,571.80** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 309,281,577.01 | 249,698,571.80 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 309,281,577.01 | 249,698,571.80 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 55,810,000.00 | 55,350,400.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 253,471,577.01 | 194,348,171.80 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,752,470,200.00** | **1,575,714,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,721,957,200.00 | 1,517,193,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,721,957,200.00 | 1,517,193,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 30,513,000.00 | 58,521,700.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,500,000.00 | 13,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,000,000.00 | 8,526,600.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 20,013,000.00 | 36,995,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,015,110,672.28** | **1,861,406,907.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,015,110,672.28** | **1,861,406,907.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,969,777,309.41 | 1,806,152,382.58 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,070,421,699.93 | 1,044,772,545.40 |
| 210101 | Үндсэн цалин | 693,069,499.93 | 680,927,099.91 |
| 210102 | Нэмэгдэл | 373,752,200.00 | 357,041,445.49 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,600,000.00 | 2,916,000.00 |
| 210104 | Урамшуулал | 1,000,000.00 | 3,888,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 22,539,237.11 | 23,468,605.12 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | - | 2,299,573.09 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 365,645.11 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 207,220.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 47,485.24 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,539,237.11 | 20,548,681.29 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 172,160,880.00 | 183,177,527.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 79,826,300.00 | 79,766,515.00 |
| 210302 | Түлш, халаалт | 76,360,880.00 | 91,603,480.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,973,700.00 | 11,807,532.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 153,015,970.92 | 70,542,861.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,014,415.00 | 3,889,098.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,713,101.00 | 30,859,750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,538,400.00 | 3,182,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 152,500.00 | 169,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,786,200.00 | 3,273,013.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 31,580,000.00 | 21,380,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 89,231,354.92 | 7,790,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 313,741,566.85 | 249,603,513.90 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 11,990,927.00 | 11,971,890.00 |
| 210502 | Хоол, хүнс | 298,165,279.85 | 232,946,086.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,585,360.00 | 4,685,537.90 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 54,482,711.11 | 19,426,210.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 356,000.00 | 290,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 54,126,711.11 | 19,136,210.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 344,000.00 | 500,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 344,000.00 | 500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 24,528,166.00 | 40,137,729.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,086,966.00 | 35,013,751.50 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,000,000.00 | 2,016,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 900,000.00 | 709,778.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 330,000.00 | 308,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,211,200.00 | 1,090,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 158,543,077.49 | 174,523,390.66 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,556,051.75 | 7,019,353.25 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,282,400.00 | 966,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 142,704,625.74 | 166,537,737.41 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 45,333,362.87 | 55,254,524.42 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 21,961,800.00 | 18,564,000.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 21,961,800.00 | 18,564,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 846,000.00 | 6,013,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 846,000.00 | 6,013,200.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,525,562.87 | 5,677,324.42 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,525,562.87 | 5,677,324.42 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 20,000,000.00 | 25,000,000.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 20,000,000.00 | 25,000,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **46,641,104.73** | **(35,993,435.20)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **46,641,104.73** | **(35,993,435.20)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,961,615,240.40** | **1,777,580,368.80** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 207,816,490.40 | 201,865,468.80 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **207,816,490.40** | **201,865,468.80** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 207,816,490.40 | 197,175,468.80 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 207,816,490.40 | 197,175,468.80 |
| 120009 | Бусад орлого | - | 4,690,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,753,798,750.00 | 1,575,714,900.00 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,720,252,500.00** | **1,517,193,200.00** |
| 131001 | **Урсгал үйл ажиллагааны санхүүжилт** | 1,720,252,500.00 | 1,517,193,200.00 |
| **1311** | Нэмэлт санхүүжилтийн орлого | 33,546,250.00 | 58,521,700.00 |
| 131101 | **Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж** | 3,033,250.00 | |
| 131103 | ЗГНХ ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,500,000.00 | 13,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,000,000.00 | 8,526,600.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 20,013,000.00 | 36,995,100.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,902,920,795.09 | 1,761,538,247.88 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,902,920,795.09** | **1,761,538,247.88** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,859,292,132.22** | **1,706,283,723.46** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,069,489,700.00** | **1,049,494,545.46** |
| 210101 | **Үндсэн цалин** | 692,137,500.00 | 685,649,099.97 |
| 210102 | Нэмэгдэл | 373,752,200.00 | 357,041,445.49 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,600,000.00 | 2,916,000.00 |
| 210104 | Урамшуулал | 1,000,000.00 | 3,888,000.00 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 22,539,237.13 | 23,468,605.12 |
| 210201 | **Тэтгэврийн даатгал** | - | 2,299,573.09 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 365,645.11 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 207,220.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 47,485.24 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,539,237.13 | 20,548,681.29 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 177,212,000.00 | 162,062,447.00 |
| 210301 | **Гэрэл, цахилгаан** | 79,826,300.00 | 79,766,515.00 |
| 210302 | Түлш, халаалт | 81,412,000.00 | 70,488,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,973,700.00 | 11,807,532.00 |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | 43,410,600.00 | 46,510,100.00 |
| 210401 | **Бичиг хэрэг** | 1,552,800.00 | 1,345,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 35,847,500.00 | 38,526,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,538,400.00 | 3,182,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 201,700.00 | 181,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,270,200.00 | 3,274,200.00 |
| **2105** | Нормативт зардал | 311,687,900.00 | 203,485,000.00 |
| 210501 | **Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл** | 10,837,900.00 | 11,431,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 300,850,000.00 | 192,053,400.00 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 34,342,310.00 | 38,210,520.88 |
| 210601 | **Багаж, техник, хэрэгсэл** | 19,056,810.00 | 6,120.88 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 890,000.00 | 890,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,395,500.00 | 37,314,400.00 |
| **2107** | Томилолт, зочны зардал | 344,000.00 | 500,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 344,000.00 | 500,000.00 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 184,554,235.09 | 175,974,805.00 |
| 210801 | **Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж** | 180,113,035.09 | 170,850,827.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,000,000.00 | 2,016,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 900,000.00 | 709,778.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 330,000.00 | 308,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,211,200.00 | 1,090,200.00 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,712,150.00 | 6,577,700.00 |
| 210901 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 14,430,450.00 | 5,611,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,281,700.00 | 966,300.00 |
| **213** | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 43,628,662.87 | 55,254,524.42 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **21,961,800.00** | **18,564,000.00** |
| 213101 | **Засгийн газрын дотоод шилжүүлэг** | 21,961,800.00 | 18,564,000.00 |
| **2132** | Бусад урсгал шилжүүлэг | 846,000.00 | 6,013,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 846,000.00 | 6,013,200.00 |
| **2133** | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 5,677,324.42 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 5,677,324.42 |
| **2135** | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 20,820,862.87 | 25,000,000.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 20,820,862.87 | 25,000,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 58,694,445.31 | 16,042,120.92 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 53,742,290.00 | 15,764,379.12 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **53,742,290.00** | **15,764,379.12** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **53,742,290.00** | **15,764,379.12** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 53,742,290.00 | 15,764,379.12 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (53,742,290.00) | (15,764,379.12) |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **4,952,155.31** | **277,741.80** |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 5,111,746.55 | 10,063,901.86 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 10,063,901.86 | 10,341,643.66 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 2,688,790,820.02 | 665,351,913.26 | 714,984,244.76 | | 4,069,126,978.04 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (3,178,507.00) | | (3,178,507.00) |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,688,790,820.02** | **665,351,913.26** | **711,805,737.76** | **-** | 4,065,948,471.04 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | (901,493.00) | - | | (901,493.00) |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 32,667,529.22 | | 32,667,529.22 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,688,790,820.02** | **664,450,420.26** | **744,473,266.98** | **-** | 4,097,714,507.26 |
| D01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,688,790,820.02** | **663,548,927.26** | **777,140,796.20** | **-** | |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 176,800.00 | | 176,800.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,688,790,820.02** | **664,450,420.26** | **744,650,066.98** | **-** | 4,097,891,307.26 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (176,800.00) | - | | (176,800.00) |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | (35,993,435.20) | | (35,993,435.20) |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,688,790,820.02** | **664,273,620.26** | **708,656,631.78** | **-** | 4,061,721,072.06 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,552,943,600.00 | 1,547,266,275.58 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,552,943,600.00 | 1,547,266,275.58 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,529,757,000.00 | 1,527,379,075.58 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,049,657,700.00 | 1,049,494,545.46 |
| 210101 | Үндсэн цалин | 685,649,100.00 | 685,649,099.97 |
| 210102 | Нэмэгдэл | 357,204,600.00 | 357,041,445.49 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2916000.00 | 2916000.00 |
| 210104 | Урамшуулал | 3888000.00 | 3888000.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 25,404,000.00 | 23,468,605.12 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | - | 2,299,573.09 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 365,645.11 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 207,220.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 47,485.24 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,404,000.00 | 20,548,681.29 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 160,644,600.00 | 160,577,447.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 72,783,900.00 | 78,281,515.00 |
| 210302 | Түлш, халаалт | 73,549,500.00 | 70,488,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 14311200.00 | 11807532.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 38,064,500.00 | 38,064,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,345,700.00 | 1,345,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 30,081,200.00 | 30,081,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,182,000.00 | 3,182,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 181,400.00 | 181,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,274,200.00 | 3,274,200.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 203,485,000.00 | 203,485,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 11,431,600.00 | 11,431,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 192,053,400.00 | 192,053,400.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 31,193,300.00 | 31,193,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 12,600,500.00 | 12,600,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 890,000.00 | 890,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 17,702,800.00 | 17,702,800.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 500,000.00 | 500,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 500,000.00 | 500,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 18,393,200.00 | 18,180,978.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,057,000.00 | 13,057,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,016,000.00 | 2,016,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 900,000.00 | 709,778.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 330,000.00 | 308,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,090,200.00 | 1,090,200.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,414,700.00 | 2,414,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,448,400.00 | 1,448,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 966,300.00 | 966,300.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 23,186,600.00 | 19,887,200.00 |
| 2131 | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 21,863,400.00 | 18,564,000.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 21,863,400.00 | 18,564,000.00 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,323,200.00 | 1,323,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,323,200.00 | 1,323,200.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,552,943,600.00 | 1,547,266,275.58 |
| 1310 | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,517,193,200.00 | 1,511,515,875.58 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,517,193,200.00 | 1,511,515,875.58 |
| 120004 | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 35,750,400.00 | 35,750,400.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 35,750,400.00 | 35,750,400.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 58,521,700.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **58,521,700.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **55,021,700.00** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,485,000.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,485,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **8,445,600.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,445,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **22,781,600.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,170,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 19,611,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **18,146,500.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 18,146,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **4,163,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,163,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **3,500,000.00** |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 3,500,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 58,521,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **58,521,700.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 13,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,526,600.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 36,995,100.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ариунаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх-419 дүгээр нээлттэй хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/117 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлж, албаны бэлэн байдал, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс 2021 онд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих ангийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх-419 дүгээр нээлттэй хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,032.2 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 20.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 15.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Тайлант онд нийт зардал буурсан учраас материаллаг байдлыг гүйцэтгэлийн үед 13.9 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх-419 дүгээр нээлттэй хорих ангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 35.8 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 10.06 | 10.34 | (0.3) |
| Авлага | 3.4 | 1.5 | 1.9 |
| Урьдчилгаа | 1.9 | 1.9 | - |
| Бараа материал | 395.6 | 390.7 | 4.8 |
| Үндсэн хөрөнгө | 3,721.0 | 3,691.6 | 29.3 |
| **Нийт хөрөнгө** | **4,131.8** | **4,096.1** | 35.8 |
| Өр төлбөр | 34.1 | 34.3 | (0.2) |
| Засгийн газрын оролцоо | 4,097.7 | 4,061.7 | 36.0 |
| Засгийн газрын оролцоо /Өмч-Төрийн/ | 2,688.8 | 2,688.8 | - |
| Өмнөх үеийн үр дүн | 744.3 | 744.5 | (0.2) |
| Тайлант үеийн үр дүн | - | (36.0) | 36.0 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 664.6 | 664.5 | 0.2 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **4,131.8** | **4,096.1** | **35.8** |

Мөнгөн хөрөнгөнд хоригдлын нэрийн дансны төрийн сангийн үлдэгдэл 0.3 мянган төгрөгөөр өсжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 4.8 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 29.3 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Авлагын үлдэгдэл 1.9 сая төгрөгөөр буурч 1.5 сая болжээ. Энэ нь дээд газрын дотоод хяналтаар тавигдсан актын төлбөрөөс үүссэн авлага байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй бөгөөд тухай байгууллагад ажиллаж байгаад халагдсан хүмүүстэй холбоотой үүссэн авлага байна. Уг авлагыг шүүхээр шийдвэрлүүлж, барагдуулахаар ажиллаж байна.

Өр төлбөр дансанд хоригдлын нэрийн дансны үлдэгдэл, бусад өглөг бүртгэгддэг. Тайлант оны өр төлбөрийн 0.2 мянган төгрөг хоригдлын цалингаас суутгасан татварын өглөг, үлдсэн 34.1 сая төгрөг хоригдлын нэрийн дансны үлдэгдэл байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,061.7 сая төгрөг болж, 36.0 сая төгрөгөөр өссөн. Өмнөх оны үр дүн 0.2 сая төгрөгөөр өссөн нь ашиглах хугацаа дууссан хөрөнгийг дахин үнэ тогтоож орлогодсонтой холбоотой үүссэн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 239.4 сая төгрөгөөр буюу 11.6 хувиар буурсан нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 153.7 сая төгрөгөөр буюу 7.6 хувиар буурсан нь цалин хөлс, нормативт зардал, хангамж, бараа материалын зардалтай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 2,436.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 677.8 сая төгрөгөөр бууруулан 1,758.8 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,758.8 сая төгрөг батлсныг 1,722.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 36.7 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,517.2 сая төгрөг, үндсэн ажиллагааны орлого 35.8 сая төгрөг нийт 1,553.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,547.3 сая төгрөг зарцуулж, 5.7 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 13.0 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 8.5 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 37.0 сая төгрөг нийт 58.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, бүрэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцлох асуудал байхгүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Аудитаар илэрсэн гол асуудал байхгүй.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд байршуулсан мэдээллийг шалгахад 375.7 сая төгрөгийн 15 худалдан авалтыг, 1,515.2 сая төгрөгийн 27 орлогын, 150.4 сая төгрөгийн 21 зарлагын мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлсэн байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, дотоод хяналтыг ажиллуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах талаар 3 зөвлөмж өгөгдсөн нь бүрэн биелжээ.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар туслах аж ахуйн орлого, бүртгэл, тооцоо түүнд тавьсан дотоод хяналтыг авч үзэх болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12.6 сая төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 5.6 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 0.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 6.4 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

### 4.1 Залруулсан алдаа

Өмнөх оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үлдэгдэл дээд газраас шилжүүлэн авсан үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг 0.3 сая төгрөгөөр дутуу бүртгэснийг залруулав.

Түлш, шатах тослох материалын тайланд 5.4 сая төгрөгийн орлого, зарлага дутуу бүртгэснийг залруулсан.

### 4.2 Төлбөрийн акт

Ээлжийн амралтын хоногийн тооцоог хийгээгүй 0.5 сая төгрөгийн цалинг давхардуулан олгосон байна.

### 4.3 Албан шаардлага

Бэлэн мөнгөний 6.4 сая төгрөгийн орлогыг тухай бүрд нь төрийн сангийн дансанд тушааж тооцоо хийгээгүй.

### 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Алдаа зөрчлийн утга | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих анги | 4 | 12.6 | 2 | 5.7 | 1 | 0.5 | 1 | 6.4 | | |
| **ДҮН** | | **4** | **12.6** | **2** | **5.7** | **1** | **0.5** | **1** | **6.4** | | |

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2022 оны 02 сарын 25 өдөр  Дугаар 02/A2370448 ХЭА-2022/08/НА-СТА-ТШЗ  Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Ээлжийн амралтын хоногийн тооцоог хийгээгүйгээс 536.8 мянган төгрөгийн цалинг давхардуулан олгосон байна.

Энэ нь ЭМ, НХС-ын 2000 оны хамтарсан тушаалаар батлагдсан "ээлжийн амралт олгох заавар"-ын 13-т "Ажил олгогч нь ажилтанг ажлаас халагдахаас бусад тохиолдолд болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол биеэр эдлээгүй ээлжийн амралтын оронд мөнгөн олговор олгож болохгүй." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т *"Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно."*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох " журмын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь::

1. Давхардуулан олгосон 536.8 мянган төгрөгийн цалинг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх
2. Актын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих ангийн дарга, хурандаа Д.Хатанбаатар, нягтлан бодогч Г.Солонго нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТОР Б.АРИУНАА

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОЮУНТУЯА

2317144297
CICA0046 9074062

023050065

Монгол Улс, Чингис хот, 3-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 98601199

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 Дугаар 21/А2370448 ХЭА-2022/08/НА-СТА-ТШЗ Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бэлэн мөнгөний тайлангаар 6,429.0 мянган төгрөгийн орлогыг тухай бүрд нь төрийн сангийн дансанд тушааж тооцоо хийгээгүй.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6-т "Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана." гэж заасныг баримталж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих ангийн дарга, хурандаа Д.Хатанбаатар, нягтлан бодогч Г.Солонго нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТОР Б.АРИУНАА

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОЮУНТУЯА

2317144297
СЮА0046 9074082

Монгол Улс, Чингис хот, 3-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 98601199

02304007